



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүүхэд залуучуудын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/73/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: В.Жавзмаа
Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 75

танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМГИЙН ХҮҮХЭД
ЗАЛУУЧУУДЫН ТЕАТРЫН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Д.БЭХБИЛЭГ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхэд залуучуудын театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүүхэд залуучуудын театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>176,991,516.29</u>	<u>176,866,174.69</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,375,000.00	725,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,375,000.00	725,000.00
3122	Гадаад валют	1,375,000.00	725,000.00
31224	Бусад төсөл, нөөцийн харилцах	1,375,000.00	725,000.00
33	АВЛАГА	2,600,007.42	2,600,007.42
335	Бусад авлага	2,600,007.42	2,600,007.42
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,600,007.42	2,600,007.42
35	БАРАА МАТЕРИАЛ	173,016,508.87	173,541,167.27
351	Түүхий эд материал	112,964,411.72	113,088,711.72
35110	Тусгай зориулалттай материал	112,964,411.72	113,088,711.72
354	Хангамжийн материал	60,052,097.15	60,452,455.55
35410	Бичиг хэргийн материал	1,242,800.00	898,200.00
35420	Аж ахуйн материал	52,795,597.15	51,969,265.55
35430	Сэлбэг хэрэгсэл	269,500.00	269,500.00
35440	Түлш, шатах тослох материал	550,000.00	1,015,800.00
35450	Барилгын засварын материал	5,194,200.00	6,299,690.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,024,553,990.45</u>	<u>988,131,728.80</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,024,553,990.45	988,131,728.80
392	Биет хөрөнгө	874,273,990.45	837,851,728.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	900,113,489.89	900,113,489.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	(78,538,436.64)	(117,807,654.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	24,600,000.00	24,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,840,000.00)	(12,300,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	91,650,997.85	111,011,517.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(85,624,341.39)	(89,406,549.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,882,872.44	76,882,872.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	(61,623,174.42)	(67,850,101.22)
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,741,440.00	24,741,440.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,088,857.28)	(12,133,285.92)
393	Биет бус хөрөнгө	150,280,000.00	150,280,000.00
39301	Программ хангамж	500,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(500,000.00)	(500,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	150,280,000.00	150,280,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,201,545,506.74</u>	<u>1,164,997,903.49</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,051,265,506.74</u>	<u>1,014,717,903.49</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,051,265,506.74	1,014,717,903.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	333,916,483.11	333,916,483.11
51101	Өмч: - төрийн	333,916,483.11	333,916,483.11
512	Хуримтлагдсан үр дүн	(189,115,986.41)	(225,663,589.66)
51210	Өмнөх үеийн үр дүн	(189,115,986.41)	(189,115,986.41)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(36,547,603.25)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	906,465,010.04	906,465,010.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,051,265,506.74</u>	<u>1,014,717,903.49</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	646,103,368.40	559,678,620.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,602,388.40	19,484,820.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,602,388.40	19,484,820.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,602,388.40	19,484,820.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,602,388.40	19,484,820.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	637,500,980.00	540,193,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,402,000.00	22,218,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,020,000.00	20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,382,000.00	2,218,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	604,448,000.00	517,975,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	604,448,000.00	517,975,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	705,507,287.26	596,226,223.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	705,507,287.26	596,226,223.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	537,160,445.68	472,231,436.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	377,023,879.00	340,353,233.05
210101	Үндсэн цалин	377,023,879.00	311,143,076.05
210102	Нэмэгдэл	-	16,270,792.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	12,939,365.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,470,566.42	44,847,528.58
210201	Тэтгэврийн даатгал	33,659,852.39	31,711,746.23
210202	Тэтгэмжийн даатгал	4,031,199.45	3,543,507.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,012,404.61	2,663,996.73
210204	Ажилгүйдлийн даатгал	706,100.09	629,844.19
210205	Эрүүл мэндийн даатгал	7,061,009.88	6,298,433.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,094,032.00	18,316,752.00
210301	Гэрэл, цахилгаан	3,628,507.00	3,831,126.00
210302	Түлш, халаалт	13,563,747.00	10,853,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,901,778.00	3,632,026.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,410,975.00	2,969,550.00
210401	Бичиг хэрэг	1,742,300.00	595,100.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	684,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	888,225.00	894,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	128,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,052,450.00	699,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,637,000.00	1,033,920.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	586,000.00	126,820.00
210604	Урсгал засвар	3,039,000.00	907,100.00
2107	Томиллолт, зочны зардал	-	458,500.00
210702	Дотоод албан томиллолт	-	458,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,699,022.00	8,469,171.60

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,513,992.00	7,114,371.60
210803	Даатгалын үйлчилгээ	-	143,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,830.00	51,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	1,264,200.00	1,127,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,824,971.26	55,782,781.65
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,824,971.26	55,782,781.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	168,346,841.58	123,994,786.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,908,662.00	44,005,865.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,040,562.00	41,866,865.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,868,100.00	2,139,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	79,988,921.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	79,988,921.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(59,403,918.86)</u>	<u>(36,547,603.25)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(59,403,918.86)</u>	<u>(36,547,603.25)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,196,483.11	906,465,010.04	(129,712,067.55)	1,260,949,425.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	484,196,483.11	906,465,010.04	(129,712,067.55)	1,260,949,425.60
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(59,403,919.00)	(59,403,919.00)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,196,483.11	906,465,010.04	(189,115,986.55)	1,201,545,506.60
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	484,196,483.11	906,465,010.04	(189,115,986.55)	1,201,545,506.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	484,196,483.11	906,465,010.04	(189,115,986.55)	1,201,545,506.60
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(36,547,603.25)	(36,547,603.25)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,196,483.11	906,465,010.04	(225,663,589.80)	1,164,997,903.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	639,769,897.00	559,700,165.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	639,769,897.00	559,700,165.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,402,000.00	22,218,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,020,000.00	20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,382,000.00	2,218,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	604,448,000.00	517,975,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	604,448,000.00	517,975,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,569,897.00	19,506,365.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,569,897.00	19,506,365.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	647,980,877.00	560,350,165.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	647,980,877.00	560,350,165.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	477,822,618.42	416,849,013.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	376,964,485.00	340,353,233.05
210101	Үндсэн цалин	328,695,548.43	311,143,076.05
210102	Нэмэгдэл	28,300,917.00	16,270,792.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,268,999.57	12,939,365.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,470,566.42	44,847,528.58
210201	Тэтгэврийн даатгал	34,500,010.26	31,816,057.47
210202	Тэтгэмжийн даатгал	3,532,757.60	3,439,196.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,069,014.51	2,663,996.73
210204	Ажилгүйдлийн даатгал	641,722.84	629,844.19
210205	Эрүүл мэндийн даатгал	6,727,061.21	6,298,433.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,094,032.00	18,316,752.00
210301	Гэрэл, цахилгаан	3,628,507.00	3,831,126.00
210302	Түлш, халаалт	13,563,747.00	10,853,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,901,778.00	3,632,026.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,515,375.00	3,028,800.00
210401	Бичиг хэрэг	846,450.00	364,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,150,000.00	1,150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	888,225.00	894,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	128,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	502,700.00	523,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,003,500.00	437,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	58,000.00	437,500.00
2107	Томилолт, зочны зардал	-	458,500.00
210702	Дотоод албан томилолт	-	458,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,473,680.00	9,406,700.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,288,650.00	8,051,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	114,480.00	143,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	53,350.00	44,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	40,500.00
210807	Газрын төлбөр	1,264,200.00	1,127,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	170,158,258.58	143,501,151.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,720,079.00	63,512,230.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,268,917.00	19,506,365.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,040,562.00	41,866,865.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,410,600.00	2,139,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	110,492,222.84	79,988,921.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	110,492,222.84	79,988,921.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(7,910,000.00)</u>	<u>(650,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(7,910,000.00)	(650,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,285,000.00	1,375,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,375,000.00	725,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	517,975,800.00	439,800,313.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	517,975,800.00	439,800,313.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	468,260,200.00	395,794,448.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	379,694,900.00	322,162,622.05
210101	Үндсэн цалин	246,965,500.00	292,952,465.05
210102	Нэмэгдэл	104,001,400.00	16,270,792.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,728,000.00	12,939,365.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,258,800.00	42,468,574.22
210201	Тэтгэврийн даатгал	36,071,000.00	29,984,312.19
210202	Тэтгэмжийн даатгал	3,796,900.00	3,302,394.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,037,600.00	2,554,554.93
210204	Ажилгүйдлийн даатгал	759,400.00	602,483.72
210205	Эрүүл мэндийн даатгал	7,593,900.00	6,024,828.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,546,100.00	18,316,752.00
210301	Гэрэл, цахилгаан	4,700,000.00	3,831,126.00
210302	Түлш, халаалт	10,346,100.00	10,853,600.00
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	3,632,026.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,224,000.00	2,932,800.00
210401	Бичиг хэрэг	917,500.00	364,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,258,100.00	1,150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	894,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	548,400.00	523,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	784,900.00	180,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	180,000.00
2107	Томиллолт, зочны зардал	616,500.00	458,500.00
210702	Дотоод албан томиллолт	616,500.00	458,500.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,135,000.00	9,275,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,000,000.00	8,051,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	287,500.00	143,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,300.00	44,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	1,003,200.00	1,003,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,715,600.00	44,005,865.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,715,600.00	44,005,865.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,215,600.00	41,866,865.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	2,139,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	507,345,800.00	517,975,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	507,345,800.00	517,975,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	507,345,800.00	517,975,800.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,375,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		725,000.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	38.00	38.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	30.00	30.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	54.00	38.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	27.00	27.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	27.00	11.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,054,565.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,054,565.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,054,565.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,190,611.00
210101	Үндсэн цалин	18,190,611.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,378,954.36
210201	Тэтгэврийн даатгал	1,831,745.28
210202	Тэтгэмжийн даатгал	136,802.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	109,441.80
210204	Ажилгүйдлийн даатгал	27,360.47
210205	Эрүүл мэндийн даатгал	273,604.54
2104	Хангамж, бараа материалын зардал	96,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	257,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	257,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	131,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	7,500.00
210807	Газрын төлбөр	124,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,218,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,218,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,218,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүүхэд залуучуудын театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор В.Жавзмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүүхэд залуучуудын театр 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүүхэд залуучуудын театр нь дэлхийн болон үндэсний сонгодог, Монгол өв соёл, ёс заншлаа эрхэмлэн дээдэлсэн иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан уран бүтээл туурвиж, дэлхийн жишигтэй хөл нийлсэн шинэ зууны монгол хүнийг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант онд "Байгууллагын материаллаг бааз, хөрөнгө оруулалтын нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлж сурталчлах, мэргэжлийн боловсон хүчнээр хангах" зорилт дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод хяналт, аудит хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүүхэд залуучуудын театр 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 517,975.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,769.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,438.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хүүхэд залуучуудын театрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,547.6 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,375.0	725.0	(650.0)
Авлага	2,600.0	2,600.0	
Бараа материал	173,016.5	173,541.2	524.7
Үндсэн хөрөнгө	1,024,554.0	988,131.7	(36,422.3)
Нийт хөрөнгө	1,201,545.5	1,164,997.9	(36,547.6)
Өр төлбөр	0.0	0.0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,201,545.5	1,164,997.9	(36,547.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,201,545.5	1,164,997.9	(36,547.6)

Мөнгөн хөрөнгийн данс 725.0 мянган төгрөг болж 650.0 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн зарцуулалтаас шалтгаалсан байна.

Авлагын дансанд өөрчлөлт ороогүй бөгөөд 1999 оноос өмнө дуу бүжгийн Эрдэнэт чуулгатай холбоотой 13 иргэн, албан байгууллагатай холбоотой бөгөөд хуулийн байгууллагад хандах нотлох баримт бүрдүүлэхэд хүндрэл үүссэн байна.

Бараа материалын данс 173,541.2 мянган төгрөг болж 524.7 мянган төгрөгөөр өссөн нь оны эцэст худалдан авсан шатахуун, тусгай зориулалтын материал, сэлбэг хэрэгсэл нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 988,131.7 мянган төгрөг болж 36,422.3 мянган төгрөгөөр буурахад тайлант оны элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,164,997.9 мянган төгрөг болж 36,547.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хүүхэд залуучуудын театрын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 86,424.7 мянган төгрөгөөр буюу 13.4 хувиар, нийт зардал өмнөх оноос 109,281.1 мянган төгрөгөөр буюу 15.5 хувиар тус тус буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хүүхэд залуучуудын театр нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 622,392.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 622,392.4 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 101,916.6 мянган төгрөгөөр бууруулан 520,475.8 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 1 удаа тодотгол хийж 2,500.0 мянган төгрөгөөр бууруулж, 517,975.8 мянган төгрөгөөр баталжээ. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг бууруулж тодотгол хийсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх соёл урлаг хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 517,975.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, урсгал үйл ажиллагаанд 439,150.3 мянган төгрөгийг зарцуулж, 78,825.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 439,150.3 мянган төгрөг буюу 84.8 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 57,532.3 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 8,790.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,229.3 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 1,291.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 2,859.8 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 6,348.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын төсөл, хөтөлбөрийн зардлаас 20,000.0 мянган төгрөгийн цирк ангийн уран бүтээлчдийн цалин, өөрийн орлогоос 2,218.0 мянган төгрөгийн үзвэр, дугуйлангийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 20,569.6 мянган төгрөгийг цирк ангийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, 495.0 мянган төгрөгийн газрын төлбөр, хог хаягдлын хураамж, ариутгал цэвэрлэгээний хэрэгсэл авахад зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно. Тус байгууллагын үзвэрийн үйл ажиллагаа 2021 оны 12 сараас хязгаарлалтгүй болсон байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хүүхэд залуучуудын театр нь 2021 онд нийт 608,890.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 588,806.4 мянган төгрөгийн 146 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлж, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Аудитын явцад цалингийн төсөв өмч, хөрөнгө зарцуулах 20,084.5 мянган төгрөгийн 4 мэдээллийг залруулсан болно.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 50.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 16,318.8 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	1	50.0	1	50.0			
Албан шаардлага							
Зөвлөмж	1	16,268.8	1	16,268.8			
Нийт дүн	2	16,318.8	2	16,318.8			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар анхаарал татах бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 684,171.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 676,879.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,291.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант оны санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны зэрэгцүүлэх үзүүлэлтийг тайлагнаагүй, бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл, санхүүгийн тайлангийн үлдэгдэл зөрүүтэй, цалингийн зардлын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд бүрэн тайлагнаагүй зэрэг алдааг нягтлан холбогдох дансанд залруулж тайлагнуулав.

Мөн шилэн дансанд мэдээлэх төсөв өмч, хөрөнгө зарцуулах 20,084.5 мянган төгрөгийн 4 мэдээллийг мэдээлээгүйг залруулж, мэдээлсэн болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Бараа материалын бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Тайлант оны эцэст худалдан авсан бараа материалын 66.7 хувийг 12 сард байгаа нь дараа оны төсвийн төлөвлөлтөд нөлөөлөхөөр байх ба бараа материалын насжилт их байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Бараа материалын насжилтын судалгаа хийж, холбогдох шийдвэрийг гаргаж, төсвийн хөрөнгийг удирдан, хяналт хэрэгжүүлэх.

2. **Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын барилга байгууламжийг эд хариуцагчид хариуцуулж карт хөтлөөгүй, баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний

стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”; 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”; 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцээгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Барилга байгууламжийг эд хариуцагчид хариуцуулан бүртгэж, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах.

3. **Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт:

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг илүү, даатгуулагчаас суутгах нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу, ХХОАТ-ыг илүү суутгаж авлага, өр төлбөр үүсэхээр байтал тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Даатгуулагч болон ажил олгогчоос тооцох нийгмийн даатгалын шимтгэл, татварын тооцооллыг баталгаажуулан, 2022 оны 06 сарын 25-ны дотор залруулж тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хүүхэд залуучуудын театр	6	684,171.2	3	676,879.3					3	7,291.9